



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/196

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 214 дүгээр
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 8 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 2,010,000.00 (хоёр сая арван мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Сонгинохайрхан дүүргийн 101, 270 дугаар цэцэрлэгт хавсралтын дагуу шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 214 дүгээр цэцэрлэг (Д.Отгонжаргал)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн 101 дүгээр цэцэрлэг (Ч.Анхтуяа)-т, 270 дугаар цэцэрлэг (М.Энхцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В.Оюумаа

В.ОЮУМАА



Нийслэлийн Фүмчийн харилцааны газрын даргын 2024 оны 03 дүгээр сарын 25 -ны өдрийн 1736 дугаар тушаалын хавсралт

Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 214 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалт-анд орсон он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	бүртгэлийн анхны үнэ / төгрөгөөр /		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага
						нэгж үнэ	нийт үнэ			
1	Сандал	2023.12.31	сайн	ш	100	15,000.00	1,500,000.00	562,500.00	937,500.00	Сонгино хайрхан дүүргийн 270 дугаар цэцэрлэг
2	Гурил зуурагч	2023.12.31	сайн	ш	1	510,000.00	510,000.00	191,250.00	318,750.00	Сонгино хайрхан дүүргийн 101 дүгээр цэцэрлэг
Шилжүүлэх хөрөнгийн нийт дүн							2,010,000.00	753,750.00	1,256,250.00	